

**“Хот Девелопмент” ХК-ийн 2015 оны
үйл ажиллагааны тайлан**

Үнэт цаас гаргагчийн нэр, оршин суугаа хаяг:

Нэр: “Хот Девелопмент” ХК

Хаяг: Улаанбаатар хот, СБД, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө-13, Лэндмарк оффисын байр, 4 давхар

Утас: 75753302, 88009111

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээлэл:

Нэр: “Хот Девелопмент” ХК

Улсын бүртгэлд бүртгэсэн огноо: 2007.08.07

Улсын бүртгэлийн дугаар: 9010387001

Регистрын дугаар: 2116812

Үйл ажиллагааны чиглэл: Бизнесийн зөвлөгөө, гадаад худалдаа

Хувьцаа эзэмшигчдийн тоо: 39,885

Үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт, хэрэгжүүлж буй төсөл:

“Хот девелопмент” ХК нь 2014 онд үйл ажиллагаагаа хэвийн явуулж цаашид компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх, шинэ салбарт үйл ажиллагаагаа эхлүүлэх ажлыг хийж ирлээ. 2013 онд хийсэн хөрөнгө оруулалтын хэмжээг барьж цаашид Чойр өртөөнд Ложистик төв байгуулах ажлыг санхүүжүүлэх, бүтээн байгуулалтанд шаардлагатай хөрөнгө оруулалтыг босгохоор төлөвлөн ажиллаж байна. Энэхүү төсөл нь нийт 40 га газрыг хамран байрлах төмөр замд холбогдох боломжтой гэдгээрээ онцлог юм. Компани одоогоор орон тоо болон бүтэц нэмэгдүүлээгүй бөгөөд тайлант хугацаанд “СиБиЭм” ХХК-р Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг гүйцэтгэн ажиллаж байна.

Гол хувьцаа эзэмшигч Файрбөрд хөрөнгө оруулалтын сангаас авсан 200,000 ам долларын хөрвөх зээлийг хөрвүүлээгүй байгаа бөгөөд цаашид нэмэлт хувьцаа гаргах компанийн үнэн цэнийг өсгөх зорилгоор уг хөрвүүлэлтийг хийх төлөвлөгөөтэй байна.

Санхүүгийн тайлангийн үзүүлэлт:

Компани санхүүгийн тайлан тэнцэл, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, хувь хүний орлогын албан татвар, үл хөдлөх эд хөрөнгийн татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар болон нийгмийн даатгаланы шимтгэлийн тайлан тооцоог цаг хугацаанд нь гаргаж, татвар, нийгмийн даатгалын байгууллагад хуульд заасан хугацаанд хүргүүлсэн.

Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд:

Компанийн 2012, 2013, 2014, 2015 оны жилийн орлогын тайлангийн үзүүлэлтээс зэрэгцүүлэн үзвэл:

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/			
	2012 он	2013 он	2014 он	2015 он
Борлуулалт	-	-	-	-
Борлуулалтын хөнгөлөлт	-	-	-	-
Цэвэр борлуулалт	-	-	-	-
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	-	-	-	-
Нийт ашиг	-	-	-	-
Үйл ажиллагааны бусад орлого	-	690,7	300,8	-
Үйл ажиллагааны зардалд	2,593.9	44,525.0	86,287.5	40,244.9
Үйл ажиллагааны бус ашиг /алдагдал /	(2,593.9)	(44,525.0)	(86,287.5)	(40,244.9)
Үйл ажиллагааны бус зардал	-	16,441.5	49,553.9	25,212.3
Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал /	(2,593.9)	(60,275.8)	(135,540.6)	(65,457.2)
Орлогын татварын зардал	-	69,1	30,1	-
Цэвэр ашиг /алдагдал /	(2,593.9)	(60,344,9)	(135,570.7)	(65,457.2)

Компани нь санхүүгийн тайлан балансыг хуульд заасан хугацаанд цаг тухайд нь гаргаж аж ахуй нэгжийн орлогын албан татварыг бүрэн төлж байгаа.

2015 оны байдлаар үйл ажиллагааны зардалд 779.0 мянган төгрөг, зээлийн хүүгийн зардалд 39,465.9 мянган төгрөг, валютын ханшийн зөрүүний алдагдал 25,212.3 сая төгрөг төгрөг болж нийт (65,457.2) мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Компанийн 2012 он, 2013 он, 2014 он, 2015 оны хөрөнгө, эх үүсвэрийн тэнцлийн үзүүлэлтүүдийг зэрэгцүүлэн үзвэл:

Хөрөнгө, өр төлбөрийн үзүүлэлтүүд	мянган /төгрөгөөр /			
	2012 он	2013 он	2014 он	2015 он
Эргэлтийн хөрөнгө	5,600.0	71,558.8	28,387.1	28,320.2
Эргэлтийн бус хөрөнгө	15,000.0	223,401.0	219,412.5	219,412.5
Нийт хөрөнгийн дүн	20,600.0	294,959.8	247,799.6	247,732.7
Богино хугацаат өр төлбөр	2,593.9	353,910.1	442,320.6	500,640.9
Урт хугацаат өр төлбөр	0	0	0	0

Эзэмшигчийн өмчийн дүн	18,006.1	(58,950.3)	(194,521.0)	(252,908.2)
Өр төлбөр, эзэмшигчийн өмчийн дүн	20,600.0	294,959.8	247,799.6	247,732.7

Санхүүгийн үйл ажиллагаанд одоогоор гарсан томоохон гүйлгээ үл хөдлөх хөрөнгө худалдан авалт хийгдээгүй байна.

Ногдол ашгийн талаархи мэдээлэл:

Компани нь 2015 онд алдагдалтай ажилласан тул ногдол ашиг тараахгүй тухай шийдвэрийг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн 100% саналаар баталсан.

Компанийн тухай хуулийн 87,89 дүгээр зүйлд заасан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийсэн эсэх талаархи мэдээлэл

Компани их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгээгүй. Компанийн хяналтын багц эзэмшигчдийн хувьд өөрчлөлт ороогүй.

Үнэт цаас гаргагчийн хяналтын багц эзэмшигчдийн мэдээлэл:

Хувьцааны 5 буюу түүнээс дээш хувийг эзэмшигч этгээд:

№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Нийт хувьцааны хувь
1	HOT HOLDINGS S.A.R.L	74,53%
2	Бидисек ХК	7,49%

Үнэт цаас гаргагчийн ТУЗ, дэд хороодын тайлан:

Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр Б.Батбаатар, Жэймс Пассин, Б.Пүрэвбаатар, Б.Лхагвадорж, Д.Даянбилгүүн, Жэймс Флорес, хараат бус гишүүдээр Б.Батхуяг, Д.Нарангоо, Т.Тамир, Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар Б.Батбаатар, Гүйцэтгэх захирлаар Б.Пүрэвбаатар улиран сонгогдож, Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргаар Ж.Энхцэцэг нар ажиллаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, гүйцэтгэх захирал нар 100 хувь компанийн засаглалын сургалтанд хамрагдсан.

Үнэт цаас гаргагчийн удирдлага, эрх бүхий албан тушаалтны танилцуулга

Үнэт цаас гаргагчийн удирдлага, эрх бүхий албан тушаалтны танилцуулга:

№	Овог нэр	Албан тушаал	Боловсрол	Ажлын туршлага
1	Б.Батбаатар	ТУЗ-ийн дарга	Дээд	Шарын гол ХК-ийн Гүйцэтгэх захирал
2	Жэймс Пассин	ТУЗ-ийн гишүүн	Дээд	Файрбөрд сангийн үүсгэн байгуулагч
3	Б.Пүрэвбатаар	ТУЗ-ийн гишүүн	Дээд	Хот Девелопмент ХК-ийн гүйцэтгэх захирал
4	Жэймс Флорес	ТУЗ-ийн гишүүн	Дээд	Шарын гол ХК-ийн Санхүү эрхэлсэн захирал
5	Д.Даянбилгүүн	ТУЗ-ийн гишүүн	Дээд	БиДиСек ХК-ийн гүйцэтгэх захирал
6	Б.Лхагвадорж	ТУЗ-ийн гишүүн	Дээд	БиДиСек ХК-ийн тэргүүн дэд захирал
7	Д.Нарангоо	ТУЗ-ийн гишүүн	Дээд	Үнэмлэхүй эрх ХХК-ийн гүйцэтгэх захирал
8	Т.Тамир	ТУЗ-ийн гишүүн	Дээд	Амайзэ ХХК захирал, архитектор
9	Б. Батхуяг	ТУЗ-ийн гишүүн	Дээд	Хэрлэн Онон Туул ББСБ гүйцэтгэх захирал

Үнэт цаас гаргагчийн ТУЗ, дэд хороодын үйл ажиллагааны тайлан, цалин урамшууллын хэмжээ, үнэт цаас эзэмшдэг талаархи мэдээлэл:

№	Овог нэр	Хараат бус гишүүн эсэх	Эзэмшиж байгаа хувьцааны тоо хувь	Цалин урамшууллын хэмжээ
1	Б.Батбаатар	Энгийн	эзэмшдэггүй	0₮
2	Жэймс Пассин	Энгийн	эзэмшдэггүй	0₮
3	Б.Пүрэвбатаар	Энгийн	эзэмшдэггүй	0₮
4	Жэймс Флорес	Энгийн	эзэмшдэггүй	0₮
5	Д.Даянбилгүүн	Энгийн	эзэмшдэггүй	0₮
6	Б.Лхагвадорж	Энгийн	эзэмшдэггүй	0₮
7	Д.Нарангоо	Хараат бус	эзэмшдэггүй	0₮
8	Т.Тамир	Хараат бус	эзэмшдэггүй	0₮
9	Б. Батхуяг	Хараат бус	эзэмшдэггүй	0₮

“Хот девелопмент” ХК 2015 оны 04 сарын 16-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулснаар дараах асуудлыг шийдвэрлэсэн.

1. Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах
2. Компанийн аудитын хорооны тайланг хэлэлцэн батлах
3. 2015 оны ажлын төлөвлөгөөг хэлэлцэн батлах
4. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
5. ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын 2015 оны зардлын төсвийг батлах
6. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-ийн гишүүдийг сонгосон бөгөөд 2015 оны 04 сарын 16-ны өдөр Төлөөлөн Удирдах зөвлөлийн хурлыг хуралдуулан ТУЗ-ийн дэргэдэх хороодыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсон.

А. Төлөөлөн удирдах Зөвлөлийн дэргэдэх Аудитын дэд хороог Б.Батхуяг, Жэймс Флорэс, Д.Нарангоо гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, Аудитын хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Батхуягийг томилсон.

Б. Төлөөлөн удирдах Зөвлөлийн дэргэдэх Цалин урамшууллын дэд хороог Б.Лхагвадорж, Д.Нарангоо, Т.Тамир гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, Цалин урамшууллын дэд хорооны даргаар ТУЗ-ийн гишүүн Б.Лхагвадоржийг томилсон.

В. Төлөөлөн удирдах Зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх дэд хороог Жэймс Пассин, Б.Батхуяг, Т.Тамир гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, Нэр дэвшүүлэх дэд хорооны даргаар ТУЗ-ийн гишүүн Жэймс Пассиныг томилсон.

Компанийн ТУЗ 2015 онд нийт 4 удаа хуралдсан бөгөөд тогтоол шийдвэрүүдийг гарган ажиллаж байна.

“Хот девелопмент” ХК 2014 оны 04 сарын 21-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулснаар дараах асуудлыг шийдвэрлэсэн.

1. Компанийн 2013 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах
2. Компанийн аудитын хорооны тайланг хэлэлцэн батлах
3. 2014 оны ажлын төлөвлөгөөг хэлэлцэн батлах
4. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
5. ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын 2014 оны зардлын төсвийг батлах
6. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах

“Хот девелопмент” ХК 2013 оны 04 сарын 11-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулснаар дараах асуудлыг шийдвэрлэсэн.

1. ТУЗ-ийн гишүүд томилох
2. 2012 оны үйл ажиллагаа, санхүүгийн тайланг батлах
3. 2013 оны бизнес төлөвлөгөө болон төсөв батлах
4. ТУЗ-ын 2013 оны төсөв батлах